

## **“Хүүхдийн анагаах” мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааг зохицуулах журам**

### **Нэг. Нийтлэг үндэслэл:**

1. 2019 оны 11 сарын 15-ны өдрийн А/513 тоот тушаалын хэрэгжилтийг хангах зорилготой.
2. Төрийн ба хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй хүүхдийн эмч нарын мэргэшлийн зэрэг шинээр авах ба ахиулах, тухайн зэргээ дахин батлахад материал бүрдүүлэх, шалгалт зохион байгуулахад мөрдөнө.

**Хоёр. Мэргэшлийн зэрэг горилогч хүүхдийн эмч дараах НИЙТЛЭГ ба ТУСГАЙ шалгуурыг хангасан байна.**

**Нийтлэг шалгуур нь ЭМС-ын тушаал 2019 оны 11 сарын 15-ны А/513 тоот тушаалд заасан болно.**

### **Ахлах зэрэг горилогч хүүхдийн эмчид тавигдах нийтлэг шаардлага:**

- Мэргэшлийн зэрэг горилж буй чиглэлээр мэргэжлийн диплом эсхүл үндсэн мэргэшлийн үнэмлэхтэй байх;
- Тухайн мэргэжил эсхүл тухайн үндсэн мэргэшлийн чиглэлээр 8-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх,
- Сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтний хувьд тухайн мэргэжил эсхүл тухайн үндсэн мэргэшлийн чиглэлээр 6-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх;
- Ажиллаж буй байгууллагаас тухайн мэргэжил/үндсэн мэргэшлийн чиглэлээр мэргэшлийн зэрэг горилохыг дэмжсэн байх;
- Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй байх (мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шаардагдах мэргэжилд хамаарна);
- Жил тутам биелүүлсэн багц цагийн сургалтын 2/3-оос доошгүй нь тухайн ажиллаж буй мэргэжил/үндсэн мэргэшлийн чиглэлээр байх;
- Тухайн мэргэжил, үндсэн мэргэжлээр ажилласан сүүлийн 3 жилийн хугацаанд ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх;

### **Тэргүүлэх зэрэг горилогч хүүхдийн эмчид тавигдах нийтлэг шаардлага:**

1. Мэргэшлийн зэрэг горилж буй чиглэлээр мэргэжлийн диплом эсхүл үндсэн мэргэшлийн үнэмлэхтэй байх;
2. Тухайн мэргэжил эсхүл тухайн мэргэшлийн чиглэлээр 13-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх,
3. Сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтний хувьд тухайн мэргэжил эсхүл тухайн үндсэн мэргэшлийн чиглэлээр 10-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх;

4. Ажиллаж буй байгууллагаас тухайн мэргэжил, мэргэшлийн чиглэлээр мэргэшлийн зэрэг горилохыг дэмжсэн байх,
5. Орон нутагт ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтний тухайд харьяалах Эрүүл мэндийн газраас тухайн мэргэжил, мэргэшлийн чиглэлээр мэргэшлийн зэрэг горилохыг дэмжсэн байх;
6. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй байх (мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шаардагдах мэргэжилд хамаарна);
7. Ажиллаж буй мэргэжил, мэргэшлийн чиглэлээр байгууллага болон бүс, орон нутгийн хэмжээнд төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт жил тутам зохион байгуулах эсхүл оролцох, үр дүнд хүрсэн байх;
8. Жил тутам биелүүлсэн багц цагийн сургалтын 2/3-оос доошгүй нь тухайн ажиллаж буй мэргэжил, мэргэшлийн чиглэлээр байх;
9. Тухайн мэргэжил, мэргэшлээр ажилласан сүүлийн 3 жилийн хугацаанд ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх;

**Зөвлөх горилогч хүүхдийн эмчид тавигдах нийтлэг шаардлага:**

1. Мэргэшлийн зэрэг горилж буй чиглэлээр үндсэн эсхүл мэргэшлийн үнэмлэхтэй байх;
2. Тухайн мэргэжил, үндсэн эсхүл төрөлжсөн мэргэшлийн чиглэлээр нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвд 25-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх;
3. Ажиллаж буй байгууллагаас тухайн мэргэжил, мэргэшлийн чиглэлээр мэргэшлийн зэрэг горилохыг дэмжсэн байх,
4. Орон нутагт ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтний тухайд харьяалах Эрүүл мэндийн газраас тухайн мэргэжил, мэргэшлийн чиглэлээр мэргэшлийн зэрэг горилохыг дэмжсэн байх;
5. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй байх (мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шаардагдах мэргэжилд хамаарна);
6. Ажиллаж буй мэргэжил, мэргэшлийн чиглэлээр байгууллага болон бүс, орон нутаг, үндэсний түвшинд төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт жил тутам зохион байгуулах, үр дүнд хүрсэн байх;
7. Жил тутам биелүүлсэн багц цагийн сургалтын 2/3-оос доошгүй нь тухайн ажиллаж буй мэргэжил, мэргэшлийн чиглэлээр байх;
8. Тухайн мэргэжил, мэргэшлээр ажилласан сүүлийн 5 жилийн хугацаанд ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх;
9. Салбарын хөгжил, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн асуудалд жинтэй хувь нэмэр оруулсан манлайлагч байх;

**ТУСГАЙ ШАЛГУУР. Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 2020 оны 08 сарын 11-ний өдрийн 12 дугаар тогтоолоор батлагдсан.**

### **“АХЛАХ” зэрэг горилогч хүүхдийн эмчид тавигдах тусгай шалгуур**

1. Хүүхдийн анагаахын чиглэлээр жил бүр 3 багц цагийн сургалтанд хамрагдсан байх
2. Хүүхдийн эмнэлзүйн анагаах ухааны чиглэлээр бүтээл хэвлүүлсэн байх (тоо хамаарахгүй)
3. Хүүхдийн анагаахын салбарын бусад мэргэжилтнүүдтэй албан ёсоор хамтран ажиллан, туршлага солилцдог байх. Үүнд:
  - Хүүхдийн эмч нарын улсын зөвөлгөөн буюу хүүхдийн эмч нарын эрдэм шинжилгээний хуралд оролцох
  - “Монголын хүүхдийн анагаах ухаан” ба мэргэжлийн бусад сэтгүүлд эмнэлзүйн тохиолдол, онолын лекц, өгүүлэл хэвлүүлэх

### **“ТЭРГҮҮЛЭХ” зэрэг горилогч хүүхдийн эмчид тавигдах тусгай шалгуур**

1. Хүүхдийн анагаахын эмнэлзүйн чиглэлээр жил бүр 3 багц цагийн сургалтанд хамрагдсан байх;
2. Хүүхдийн анагаахын эмнэлзүйн чиглэлээр сүүлийн 3 жилд мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан байх;
3. Сүүлийн 5 жилд хүүхдийн эмнэлзүйн анагаах ухааны чиглэлээр 2 ба түүнээс олон бүтээл хэвлүүлсэн байх;
4. Хүүхдийн анагаахын салбарын бусад мэргэжилтнүүдтэй албан ёсоор хамтран ажиллан, туршлага солилцдог байх. Үүнд:
  - Хүүхдийн эмч нарын улсын зөвөлгөөн буюу хүүхдийн эмч нарын эрдэм шинжилгээний хуралд оролцох
  - “Монголын хүүхдийн анагаах ухаан” ба мэргэжлийн бусад сэтгүүлд эмнэлзүйн тохиолдол, онолын лекц, өгүүлэл хэвлүүлэх

### **“ЗӨВЛӨХ” зэрэг горилогч хүүхдийн эмчид тавигдах тусгай шалгуур**

1. Хүүхдийн анагаахын эмнэлзүйн чиглэлээр жил бүр 3-5 багц цагийн сургалтанд хамрагдсан байх;
2. Олон улсад мэргэжил дээшлүүлэх урт ба богино хугацааны сургалтанд 5 жилд 2-оос доошгүй удаа хамрагдсан эсвэл мэргэшлийн чиглэлээр хуралд оролцсон байх;
3. Сүүлийн 5 жилд хүүхдийн эмнэлзүйн анагаах ухааны чиглэлээр жил бүр бүтээл хэвлүүлсэн байх;
4. Хүүхэд судлалын чиглэлээр сурах бичиг, гарын авлага бичих, мэргэшил арга зүйн чиглэлээр бодлогын баримт бичиг боловсруулахад оролцсон байх;
5. Хүүхдийн анагаахын салбарын бусад мэргэжилтнүүдтэй албан ёсоор хамтран ажиллаж, туршлага солилцдог үндэсний хэмжээнд зөвлөн туслах үйл ажиллагаа хийдэг байх. Үүнд:
  - Хүүхдийн эмч нарын улсын зөвөлгөөн буюу хүүхдийн эмч нарын эрдэм шинжилгээний хуралд оролцох

- “Монголын хүүхдийн анагаах ухаан” ба мэргэжлийн бусад сэтгүүлд эмнэлзүйн тохиолдол, онолын лекц, өгүүлэл 1-р нэрээр буюу хариуцлагатай зохиогчоор хэвлүүлэх

## **ГУРАВ. МЭРГЭШЛИЙН ЗЭРГИЙН ТАЙЛАН ИРҮҮЛЭХ**

Ахлах ба тэргүүлэх зэрэгтэй эмч нар 5 жилийн дараа доорх шалгуур үзүүлэлтийн дагуу ажлын тайланг Монголын Хүүхдийн Анагаахын Академид ирүүлнэ. Зөвлөх зэрэг ажиллах бүхий л хугацаанд хүчин төгөлдөр байна.

### **“Ахлах” зэрэг**

1. 5 жилийн ажлын тайланг гаргаж байгууллагын дарга, захирлаар баталгаажуулсан байна.
2. Хүүхдийн анагаахын чиглэлээр жил бүр 3 багц цагийн сургалтанд хамрагдсан байх
3. Хүүхдийн эмнэлзүйн анагаах ухааны чиглэлээр ахлах зэрэг авснаас хойш 2 бүтээл хэвлүүлсэн байх;
4. Хүүхдийн анагаахын салбарын бусад мэргэжилтнүүдтэй албан ёсоор хамтран ажиллаж, туршлага солилцдог байх. Үүнд:
  - Хүүхдийн эмч нарын улсын зөвөлгөөн буюу хүүхдийн эмч нарын эрдэм шинжилгээний хуралд оролцох
  - “Монголын хүүхдийн анагаах ухаан” ба мэргэжлийн бусад сэтгүүлд эмнэлзүйн тохиолдол, онолын лекц, өгүүлэл хэвлүүлэх

### **“Тэргүүлэх” зэрэг**

1. 5 жилийн ажлын тайланг гаргаж байгууллагын дарга, захирлаар баталгаажуулсан байна.
2. Хүүхдийн анагаахын эмнэлзүйн чиглэлээр жил бүр 3 багц цагийн сургалтанд хамрагдсан байх;
3. Хүүхдийн анагаахын эмнэлзүйн чиглэлээр сүүлийн 3 жилд мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан байх;
4. Тэргүүлэх зэрэг хамгаалснаас хойш буюу сүүлийн 5 жилд хүүхдийн эмнэлзүйн анагаах ухааны чиглэлээр 3 ба түүнээс олон бүтээл хэвлүүлсэн байх;
5. Хүүхдийн анагаахын салбарын бусад мэргэжилтнүүдтэй албан ёсоор хамтран ажиллан, туршлага солилцдог байх. Үүнд:
  - Хүүхдийн эмч нарын улсын зөвөлгөөнд оролцох буюу хүүхдийн эмч нарын эрдэм шинжилгээний хуралд оролцох
  - “Монголын хүүхдийн анагаах ухаан” ба мэргэжлийн бусад сэтгүүлд эмнэлзүйн тохиолдол, онолын лекц, өгүүлэл хэвлүүлэх

## **ДӨРӨВ: МЭРГЭШЛИЙН ЗЭРГИЙН ХУГАЦАА**

1. Ахлах, тэргүүлэх зэрэг анх олгосноос хойш тасралтгүй 10 жил ажилласны дараа 1 удаа тухайн мэргэшлийн зэргийг давтан хамгаалах шаардлагатай бөгөөд амжилттай давтан хамгаалсан нөхцөлд цааш ажиллах бүхий л хугацаанд хүчин төгөлдөр байна.
2. Засгийн газрын тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын хүрээнд 5 жил тутам ажлын тайланг Монголын Хүүхдийн Анагаахын Академид ирүүлж баталгаажуулсан тохиолдолд мэргэшлийн зэргийг шинэчлэн тогтоосонд тооцно.
3. Ахлах зэрэг анх олгосноос хойш 5 жилийн дараа, тэргүүлэх зэрэг олгосноос хойш 12 жилийн дараа мэргэшлийн зэргийн нийтлэг ба тусгай шалгуурыг хангасан тохиолдолд дараагийн шатлал ахиулах боломжтой болно.
4. Хүүхдийн мэргэшлийн зэрэгтэй эмч тухайн мэргэжлээр 25 ба түүнээс жил тасралтгүй ажилласан нөхцөлд мэргэшлийн зэргийн давтан хамгаалах шалгалтыг тайлан хамгаалалтаар өгнө. 25 жил хүртэл ажиллаж байгаа ахлах, ба тэргүүлэх зэрэгтэй эмч онолын ба гардан үйлдлийн шалгалт өгч амжилттай давсан нөхцөлд тухайн зэргээ баталсанд тооцно.

## **ТАВ. МЭРГЭШЛИЙН ЗЭРГИЙГ ТАЙЛАНГААР ДАВТАН ХАМГААЛАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

### **5.1. “Ахлах” зэрэг тайлангаар хамгаалах эмчид тавигдах тусгай шаардлага**

#### **5.1.1. Заавал биелүүлэх шалгуур:**

1. Мэргэжлээрээ 25-аас дээш жил ажилласан байх
2. Олон нийтэд зориулсан ЭМСС-ны гарын авлага 5-оос цөөнгүйг хэвлүүлж, баталгаажуулсан байх
3. Орон нутагт хэрэгжүүлэх удирдамж, заавар, стандартын зохиогч, хэрэгжүүлэгч байх
4. “Монголын хүүхдийн анагаах ухаан” ба мэргэжлийн бусад сэтгүүл эмнэлзүйн тохиолдол, онолын лекц, өгүүлэл хэвлүүлэх
5. Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, ховор тохиолдол 10-аас доошгүйг нийтлүүлсэн, хэлэлцүүлсэн байх, үүний 50 хувь нь нэгдүгээр нэрээр байх.
6. Хүүхдийн эмч нарын улсын зөвөлгөөн буюу хүүхдийн эмч нарын эрдэм шинжилгээний хуралд оролцох
7. Эмнэлзүйн ба НЭМ-ийн үр дүнтэй үйл ажиллагаа зохион байгуулж, үр дүн нь эрүүл мэндийн үзүүлэлтээр баталгаажигдсан байх.

#### **5.1.2 Нэмэлт шалгуур:**

8. Оношилгоо, эмчилгээний шинэ арга, патент, MNS, АЗГ, ШБОС нэвтрүүлсэн байх

## **5.2. “Тэргүүлэх” зэрэг тайлангаар хамгаалах эмчид тавигдах тусгай шаардлага**

### **5.2.1. Заавал биелүүлэх шалгуур:**

1. Мэргэжлээрээ 25-аас дээш жил ажилласан байх
2. Олон нийтэд зориулсан ЭМСС-ны гарын авлага 5-аас цөөнгүйг хэвлүүлж, баталгаажуулсан байх
3. Орон нутагт хэрэгжүүлэх удирдамж, заавар, стандартын зохиогч, хэрэгжүүлэгч байх
4. “Монголын хүүхдийн анагаах ухаан” ба мэргэжлийн бусад сэтгүүлд эмнэлзүйн тохиолдол, онолын лекц, өгүүлэл, ховор тохиолдол 5-аас дээш, үүнээс нэгдүгээр нэрээр 2-3 судалгааны өгүүлэл хэвлүүлсэн байх.
5. Эрдэм шинжилгээний илтгэл 10-аас доошгүйг нийтлүүлсэн, хэлэлцүүлсэн байх
6. Хүүхдийн эмч нарын улсын зөвөлгөөнд оролцох буюу хүүхдийн эмч нарын эрдэм шинжилгээний хуралд оролцох
7. Эмнэлзүйн ба НЭМ-ийн үр дүнтэй үйл ажиллагаа зохион байгуулж, үр дүн нь эрүүл мэндийн үзүүлэлтээр баталгаажигдсан байх.
8. Эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн чиглэлээр 2-оос доошгүй төсөлт ажил санаачилж, хэрэгжүүлсэн байх

### **5.2.2. Нэмэлт шалгуур:**

1. Гадаадын сэтгүүлд өгүүлэл нийтэлсэн байх
2. Оношилгоо, эмчилгээний шинэ арга, патент, MNS, АЗГ, ШБОС 2-оос доошгүйг нэвтрүүлсэн байх

## **Мэргэшлийн зэрэг горилогч хүүхдийн эмчийн бүрдүүлэх материал:**

1. Мэргэшлийн зэргийн шалгалтад орохыг хүссэн хувийн өргөдөл;

2. Байгууллагын даргын баталгаажуулсан мэргэшлийн зэрэг горилогчийн бүрэн бөглөсөн хүсэлтийн маягт (Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын шийдвэрээр баталгаажуулсан загвараар);
3. Орон нутгийн эмнэлгийн мэргэжилтний тухайд харьяалах аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газраас дэмжсэн тодорхойлолт, албан бичиг;
4. Нийтлэг ба тусгай шаардлагыг хангасныг баталгаажуулах баримт бичиг;
5. Эмчлэх эрхийн зөвшөөрлийн хуулбар;
6. Үндсэн, төрөлжсөн мэргэшлийн үнэмлэхний хуулбар;
7. Мэргэшлийн зэрэг өмнө нь хамгаалсан бол шийдвэр, үнэмлэхний хуулбар;
8. Иргэний үнэмлэхний хуулбар;
9. НДД-ийн хуулбар;
10. 3x4 хэмжээний зураг 2 хувь (сүүлийн 6 сард авахуулсан);